

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

### С.БУЯННЭМЭХИЙН СЭТГҮҮЛЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТ

Т.Баасансүрэн\*

\*Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор

**Түлхүүр үг:** эрхлэгчийн зурвас, уран нийтлэл, редакцын өгүүлэл, чулуун бар, шинэ сэтгүүл зүй, хувьсгалт хэвлэл

Өнгөрсөн зууны 20-иод онд Монголоос Өвөр Монгол ба Буриад Монголд уригдаж ажилласан ганцхан хүн байдаг. Энэ бол С.Буяннэмэх. Тэр “Дотоод Монголын ардын сэтгүүл”-д ажиллахдаа “Эрхлэгчийн зурвас”-аар сэтгүүлийнхээ нийтлэлийн бодлогыг оновчтой тодорхойлж байсан. Одоо уг сэтгүүлийн талаар арай дэлгэрүүлэн авч үзье. Ийм боломжийг бидэнд “Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийг Хөх хотын номын сангаас сөхөн үзэж өөрийн гараар имэрдсэн Х.Зандраабайдий гуай олгож байна.

Уг номын санд тус сэтгүүлийн нийт 9 дугаараас 3 дугаар хадгалагдаж байгаа юм байна. С.Буяннэмэх 1920 онд Эрхүү хотноо “Монголын үнэн” сонины 6 дугаар гаргаж байсан бол энд Өвөр Монголд “Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийн 9 дугаарыг гардан эрхэлжээ. Тус сэтгүүл нь Дотоод Монголын Ардын хувьсгалт намын /АХН/ Төв хорооны сэтгүүл юм. 1925 оны 10-р сарын 13-нд эхэлж хуралдсан Дотоод Монголын АХН-ын анхдугаар их хурлаас шинэ сэтгүүл гаргахаар шийд-

вэрлэж, ТХ-ны тэргүүлэгч гишүүн, зохиолын хэлтсийн эрхлэгч С.Буяннэмэх буюу Цэцэнбилэгтийг эрхлэгчээр, ТХ-ы тэргүүлэгч Алтанг сэтгүүл хэвлүүлэгчээр томилжээ. Арав хоног тутамд нэг дугаар гаргахаар зорьжээ. 25x18 см-ийн хэмжээтэй цаасан дээр чулуун бараар монгол бичгээр хэвлэж гаргаад Дотоод монгол даяар тарааж байсан байна. Анхны нь дугаар 1925 оны 11-р сарын 6-нд гарчээ.

“Өргөн олон монголчуудын аж төрөх эрх ашигт зориулж үнэн байдлыг мэдээлэн, олон түмний буруу балархай танилтыг арилгаж, соёл мэдлэгийг нь дээшлүүлэхийг зорилгоо болгожээ. Тус сэтгүүл Октябрийн хувьсгал болон Дундад улсыг түрэмгийлэн эзэрхэж байсан эзэрхэг түрэмгийтэн, жич Монголын ард түмнийг уриалан хувьсгалд оролцуулах зэргийг гол агуулга болгосон бөгөөд бас сонин мэдээ мэдээлэл, хувьсгалт утга зохиолын бүтээлүүдийг нийтэлж байжээ”<sup>1</sup> гэж зохиолч Х.Зандраабайдий тэмдэглэжээ. Тэрбээр тус сэтгүүлийн 3 дугаарыг нэгбүрчлэн үзэж сэтгүүлийн шинж байдал, онцлогт ажиглалт хийснээ “Дотоод Монголын ардын сэтгүүл” өгүүлэлдээ дэлгэрэнгүй тэмдэглэн бичсэн байна.

Дотоод Монголын АХН-аас эрхлэн гаргаж байсан учир тус сэтгүүл нь улс төр, уран сайхны өнгө аястай, “Засаг төрийн анги”, “Нам бүлгийн анги”, “Сэргээн дуудах уриа”, “Чухал сонсголын анги” гэсэн тогтмол булантай байжээ. Намын мөрийн хөтөлбөрийн зорилт, төрийн бодлогыг тайлбарлан шүүмжлэлт мэдээллүүдийг дагалдуулдаг байжээ. Анхныхаа дугаарт намын анхдугаар их хурлаас гаргасан тунхагийг нийтэлжээ. Тэр тунхагт: “Хятад үндэстнүүдийн цэргийн эрхтнүүдийн ганцаар эзэрхэг ба салган ноёрхох ноёрхлоос болж Монголын ард түмэнд тулгарсан гай гамшиг нь хятадын ард түмнийхээс нэн хүнд хэцүү болжээ. Шинэ монгол орны хагацсан байдал нь хятад үндэстний орныхоос хэцүү байна. Монголын ван гүн хятад үндэстний цэргийн эрхтэн баяд ноёд ба зальхай худалдаачидтай хуйвалдан нэг замаар замнаж тэднүүсийн эрхийг хамгаалахын тусад Монголын ард түмний аливаа эрх ашгийг харамгүй худалдана”<sup>2</sup> гэж дурджээ.

“Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийн өгүүлүүдийн утга санаа товч тодорхой, хэмжээ нь богинохон, хэллэг нь яруу байгааг ажиглахад аргагүй бичиг соёлтой, чадамгай найруулагч зохиолч хүн сэтгүүлийг гардан удирдаж байсан нь илэрхий харагдана”<sup>3</sup> гэж Х.Зандраабайдий онцлоод тус сэтгүүл олон улсын байдал, түүний дотор гадаад Монголын талаар сонирхолтой мэдээлэл гаргаж байсныг жишээ баримтаар дурджээ. “Гадаад монгол Оросын гарт орсон уу?” гэж асуулт тавиад түүндээ “Гадаад монгол Оросын гарт орсон бишээ, Оростой найрамдсан юм. ЗХУ Гадаад Монголыг дарлаж доромжлохыг бодсонгүй, харин бие даасан улс болохыг зөвшөөрөхийн хамт харилцан нөхөр хань мэт туслалцах болж най-

рамдлын хэлэлцээр байгуулсан юмаа”<sup>4</sup> гэж хариулжээ. Энэ мэтээр Монголын тухай 7 асуулт тавиад тус бүрт нь хариулт өгч Монгол Улс бол бие даасан тусгаар бүгд найрамдах улс гэдгийг баталж нотолсон нь дотоод Монголын уншигчдад зөв ойлголт өгөхөд чиглэгджээ.

**М**онголтой холбоотой өөр нэг сонирхолтой мэдээлэл гарсан нь Дотоод Монголын АХН-ын Их хуралд МАХН-ын өмнөөс оролцож үг хэлсэн Намын ТХ-ны дарга Ц.Дамбадоржийн тухай аж. Тэрбээр тус их хуралд уригдаж ирсэн нь их завшаан болов. Миний бие урьд олон хуралд оролцсон боловч энэхүү хурал мэт өв тэгш хөгжилтэй, гайхамшигтай хурал тохиолдсонгүй. Ертөнцийн их бага үйлсийг бүтээхэд эрхиш олон нийтээр зорилт журмаа бат чанга сахиж, үүсгэл төгсгөлийг нь сайтар бодож, нэгэн сэтгэлээр зүтгэж явах юм бол үл бүтэх зүйлгүй хэмээн хэллээ гэж уг сэтгүүлд мэдээлжээ.

Уг сэтгүүлд товч мэдээг ихэд шуурхайлдаг, “Чухал сонсголын анги” буландаа “Жан золингийн суудал дороос галт бөмбөг дэлбэрэв”, “Дотоод Монголын цэрэг чухал цагт мандав”, “Ардын толгой дээр хэдэн ташуур байна вэ?” зэргээр гарчиглаж гаргадаг байсан байна.

“Засаг төрийн анги” буландаа Дундад улсын дотоод амьдралын талаар хурц өгүүлүүдийг нийтэлдэг байсан аж. Жишээ нь “Дундад улсын байдал” хэмээх өгүүлэлд “Эдүгээгийн дундад улсын байдал бол нэгэнт самууран эвдэрсэн үе бөгөөд муж мужийг эзэлсэн цэргийн эрхтнүүд хоорондоо эрх булаалдан байлдан тэмцэлдсэний хөлд Хятадын олон түмэн ард үхэж үрэгдэх нь тоолшгүй болжээ. Тэдгээр цэргийн эрхтэн гагцхүү цэргийн

хүчийг эрхлэн олон ардын амьдрал хөрөнгийг албадан булаан авч байна”<sup>5</sup> гэх зэргээр бичиж байжээ. Өвөр Монголын эрдэмтэн Төгсцогт, Ван Шиулан нар “Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм” номдоо “Дотоод Монголын ардын сэтгүүл” урьдах олон сонин сэтгүүлд дурьдаж чадаагүй байсан Дундад улсын нийгмийн байдалд зөв дүгнэлт өгч чадсан юм. Үүгээрээ тус сэтгүүл хэр хэмжээгээ харуулж чадсан байна”<sup>6</sup> гэснийг онцолсон тэмдэглэсэн байна. Уг сэтгүүлийн өвөрмөц онцлогийн талаар Х.Зандраабайдий бас сонирхолтой хэдэн зүйлийг тэмдэглэжээ. “Дотоод Монголын ардын сэтгүүл” нь ӨМӨЗО-ны хувьсгалт хэвлэлийн түүхэн дэх хоёр дахь сэтгүүл ажээ. Өмнө нь “Монголын тариаланч ард” гэдэг сэтгүүл 1921 оны 1-р сараас 1925 оны эхний хагас хүртэл гарч байж. Залгуулаад “Дотоод Монголын ардын сэтгүүл” мэндэлсэн байна.

**У**г сэтгүүл үг хэллэг яруу тунгалаг, 15-20-хон мөрөөр зорилгоо ойлгуулж чаддаг, урьд өмнө нь Өвөр Монголд хэний ч олж сонсоогүй сонин зүйл, шинэ нэр томъёог хэрэглэж соён гэгээрүүлдэг байсан байна. Октябрийн хувьсгал, эзэрхэг түрэмгий этгээд гэх зэрэг шинэ нэр хэллэгийг ойлгомжтой тайлбарлан ойлгуулж чаддаг байжээ. Сэтгүүлийн нийтлэл ойлгомжтой, тодорхой байсны нэг эх сурвалж нь урьдын адил хятад бичгээс орчуулалгүй шууд монголоор бичиж найруулдаг байсантай холбоотой байжээ.

Сэтгүүлийн бүтэц, хэлбэр нь оросын хэвлэлтэй төстэй байжээ. Сэтгүүлд тус редакцын өгүүлэл, дагавар өгүүлэл нийтлэгдэж, цаг үеийн шуурхай мэдээ мэдээлэл сурвалжлагыг байнга гаргадаг байсан байна. Бас уран зохиолын байнгын булантай, дугаар бүрт шүлэг зохиол нийтлэгддэг. Мөн

шог хошин зурагтай байжээ. Тэдгээрийн ихэнхийг С.Буяннэмэх өөрөө гардан хийдэг байжээ. Эдгээр нь өрнийн хэвлэлд элбэг ч дорнын хэвлэлүүдэд тухайн цаг үед хэвшиж нэвтрээгүй шинэ зүйлс байжээ.

Түүнчлэн “Дотоод Монголын ардын сэтгүүл” нь шинэ намын анхны сэтгүүл, Өвөр Монголд чулуун бараар хэвлэгдэж гарсан хамгийн сүүлчийн сэтгүүл юм байна. С.Буяннэмэхийг ер нь шинэ Монголын түүхэн дэх хөрш зэргэлдээх гадаадын улс оронд анхлан уригдаж ажилласан монгол хэл, уран зохиолын анхдагч мэргэжилтний нэг гэж үзэх үндэстэй юм. 1926-1927 онд Улаан-Үүд хотод уригдан ажиллаж байхдаа түүний бичиж үлдээсэн “Буриад Монголын үсэг бичгийг залруулан бичих заавар” хэмээх гар бичмэл эхээс энэ нь давхар батлагдана. Түүндээ С.Буяннэмэх Автономит Буриад Монголын эрдмийн хүрээлэнгийн анхдугаар их хурлаас “Өөрийн үндэсний хэл бичгийг хөгжүүлэх ба нийт Монголын бичгийн дүрэмд орох явдлыг чухал болгон тогтоосон болой” гэж тэмдэглээд “Нийт Монголын бичгийн дүрмийг зохиох нь эрхбиш Монгол улсын Судар бичгийн хүрээлэн лүгээ нийлж гүйцэтгэвээс зохих тул энэ хэргийг манай хүрээлэнгээс даруйхан явуулахаар шамдан буй... Дараагаар нийт Монголын их бичгийн дүрмийг зохион гаргахын тухайд нийтээр журамлан дагаж явсугай хэмээн зарласан үүнийг харьяат Буриадын бичигч зохиогч орчуулагч нараас тэргүүлэн цөм бүгдээр мөрдөн дагаж нэгэн замыг олбоос зохимой”<sup>7</sup> гэж бичжээ.

Энэ бол Ар Монголын эх хэлний мэргэжилтэн, зохиолч судлаач С.Буяннэмэхээс Буриад Монголын ард иргэд, мэргэжил нэгтнүүддээ өгсөн үнэт зөвлөмж мөн болой. Ингэж тэр Өвөр

Монголд ч, Буриад Монголд ч монгол хэл бичгээ дэлгэрүүлэхэд хүчин зүтгэж шинэ сэтгүүл зүй, утга зохиолыг сурталчилж явсан байна.

С.Буяннэмэх нь 1920 онд Эрхүү хотноо хэвлэгдэж Монголын хилээр нууцаар оруулж ирж ард иргэд, журамт цэргүүд, нийслэл Хүрээнээ сэм тарааж байсан “Монголын үнэн” сониныг гардан эрхэлж гаргагчийн нэг билээ. Тэр сүүлд шинэ Монгол Улсын сонин, сэтгүүлд

идэвхйлэн ажиллаж заримыг нь эрхлэн гаргаж байв. Ялангуяа ардын засгийн газраас анхлан гаргаж байсан утга зохиолын сонин бичиг, сэтгүүлийн үйлсэд түүний оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг нэн их юм. Хэсэгхэн хугацаанд Өвөр Монголд ажиллаж амьдрахдаа ч сэтгүүл гаргалцаж Цэцэнбилэгт

нэрээр хэвлүүлж байсныг энд дэлгэрэнгүй өгүүллээ. Үүн дээр нэмж зарим зүйлийг тодотгоё.

“Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийн 1925 оны 11-р сарын 16-ны өдөр хэвлэгдсэн анхны дэвтэрт “Сэтгүүлийн эрхлэгчээс” гэсэн материал нийтлэгдсэн байна. Сэтгүүлийн эрхлэгч нь Цэцэнбилэгт, хэвлэлийг эрхлэгч нь Алтан гэдэг хүн байжээ. “Олон нийтэд тус сэтгүүл гаргасны учрыг илтгэх” нь хэмээсэн эрхлэгчийн үгэнд “Сэтгүүл хэмээгч хүний явдлын

чухал зүйл бөгөөд дэлхий дахиныг сайжруулж ч чадмуй, самруулж ч чадмуй. Хүн сэтгүүл сониныг үзмэгц даруй дэлхий дахины явдлыг мэдмүй. Дэлхий дахины явдлыг мэдвээс эрхбиш оюунбилэг нэмэгдэж сайн муугийн ялгалыг таниад зам мөрөө олж болмуй. Тийнхүү сэтгүүл сонин хэмээгч хүний аж амьдрал ба, хүмүүжих боловсрохын явдалд зайлшгүй хэрэгтэй өдөр бүрийн сургууль болой. Эдүгээгийн цагт дэлхий

дахины олон улс нэгэнтээгүүр сонин бичгээр байлдаан үйлдэж, нөгөөтэйгүүр олон ардын толгойг төөрүүлэн тэднийг эрх дарлалдаа оруулахад дөхөм болгомуй. Учир явдал иймээс одоо бид нар чухамхүү өөрийн Монголын сэтгүүл сониныг гаргаж нэгэнд олон монгол ардын аж амьдрал ашиг тусыг хамгаалан бадруулах ба хоёрд, олон түмний

төөрсөн будлиантсаныг алдарган, чухамхүү

үнэн явдлын сонсгол ариун шударга мөрийг илтгэх ба, гуравт ард түмний эрх чөлөө эрдэм соёлыг бадруулах зэргийг гол болгосон болой”<sup>8</sup> хэмээжээ.

С.Буяннэмэх дотоод Монголд очихдоо аль хэдийнээ сонин сэтгүүлийн арвин туршлага хуримтлуулсан ажилтан болчихсон байжээ. Тэрбээр бүр 1920 онд “Монголын үнэн” сониныг гаргах явцад олж авсан сэтгүүлчийн мэдлэг чадвараа улам ахиулж эх орондоо эргэж ирээд хувьсгалын ажилд



**С.Буяннэмэх дотоод Монголд очихдоо аль хэдийнээ сонин сэтгүүлийн арвин туршлага хуримтлуулсан ажилтан болчихсон байжээ. Тэрбээр бүр 1920 онд “Монголын үнэн” сониныг гаргах явцад олж авсан сэтгүүлчийн мэдлэг чадвараа улам ахиулж эх орондоо эргэж ирээд хувьсгалын ажилд идэвхйлэн оролцож олон түмний дунд ухуулга таниулгын ажлыг эрчимжүүлэхэд биечлэн үлгэрлэж театр, ший жүжгийг Монголд хөгжүүлэхэд хичээнгүйлэн зүтгэсэн нь нэг ёсны “амьд сонин” гаргаж байсан хэрэг байв**



идэвхйлэн оролцож олон түмний дунд ухуулга таниулгын ажлыг эрчимжүүлэхэд биечлэн үлгэрлэж театр, ший жүжгийг Монголд хөгжүүлэхэд хичээнгүйлэн зүтгэсэн нь нэг ёсны “амьд сонин” гаргаж байсан хэрэг байв. Монголын нийгэм харанхуй бүдүүлэг, хүн амын ихэнх бичиг үсэг мэдэхгүй байсан тухайн цаг үед ший жүжиг “амьд сонин”-ы үүргийг гүйцэтгэж байжээ. Ийм “амьд сонин”-ыг С.Буяннэмэхээс гадна Ч.Дашням, Д.Нацагдорж, Ши.Аюуш зэрэг тэр үеийн сэхээтэн зохиолч, яруу найрагчид жүжгийн зохиолдоо ашигладаг байжээ... Ший жүжгийн бүлгэмээ тэд “Амьд сонин” гэж нэрлээд сониныхоо зорилгыг

Амьд сониноор уламжлан

Ардын хувьсгалт намын суртлыг

Аль болох зохих аргаар

Ард олонд нэвтрүүлэе гэж дууны аяар дуулж сурталчилж байжээ”<sup>9</sup> хэмээн судлаач М.Зулькафиль, Б.Уянга нар тэмдэглэсэн байна.

С.Буяннэмэх нь “Ардын үндэсний эрх”, “Үнэн” сонинд нарийн бичгийн даргаар ажиллаж байсны зэрэгцээ “Монгол ардын үндэсний соёлын зам”, “Шинэ толь”, “Улаан туяа” зэрэг сэтгүүлийг эрхлэн гаргаж байв. Хувьсгалт залуучуудын эвлэл, Сүхбаатарын нэрэмжит клуб, Цэнгэлдэх хүрээлэнгийн дарга, Уран зохиолчдын дугуйлан, Монголын уран зохиолчдын товчооны дарга, Уран сайхны зөвлөлийн даргаар ажиллаж байхдаа сонин хэвлэл, радио зэрэг хэвлэл мэдээллийн газруудтай хамгийн ойр дотно нягтаар хамтран ажиллаж байсан аж. Ганцхан жишээг дурдахад С.Буяннэмэх 1929 онд хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмийг үүсгэн байгуулалцаж тус бүлгэмийн тэргүүлэгчээр сонгогдоод “Уран үгсийн чуулган” хэмээх анхны цоморлигийг гардан хэвлүүлж байсан нь

үүний тодорхой илрэл юм. Сүүлд 1934 онд Уран зохиолчдын холбооны даргаар сонгогдоод “Монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдын холбооноос даруйхнаа гүйцэтгэх ажлууд”-ыг төлөвлөхдөө үндсэн 7 зүйлийг буюу тэргүүн ээлжинд утга үзэсгэлэнт ханын зохиол, уран сайхны радио эгшигт үдэш, уран үгсийн чуулганы дэвтэр хэмээн чухалчлан төлөвлөсөн байдаг. Тухайн цаг үе, Монголын нийгмийн байдал, түүний дотор өөрийнх нь эрхэлсэн ажил алба нь С.Буяннэмхийн бүтээл туурвилд нь илэрхийгээр нөлөөлж байсныг зохиолчийн “Сонин бичиг”, “Үргэлжлэн дэлгэрч байгаа үндэсний уран сайхан”, “Радио буудлыг нээх тухай”, “Уянгат сайхан радио эгшиг” зэрэг шүлэг, “Том жижиг тугалган үсгийн уран хошин яриа” үлгэр өгүүллэгээс нь төвөггүй харж болно.

**С**.Буяннэмэх бол шинэ Монгол Улсын шинэхэн сэтгүүл зүйн анхдагч зүтгэлтнүүдийн нэг яах аргагүй мөн бөгөөд “Гайхамшигт учрал” хэмээх найруулал нь Монголын сэтгүүл зүйн түүхэнд мөнхрөн үлдсэн билээ. Манай сэтгүүл зүйн нэртэй судлаач доктор Г.Дэлэг: “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” нэг сэдэвт бүтээлд С.Буяннэмэх “Монголын үнэн” сониныг хэвлүүлэхэд оролцсоныг дурдаад “Монголын хэвлэл” ботидоо өмнөх санаагаа нэлээд дэлгэрүүлж түүний бүтээл туурвилд үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг. Тэрбээр “Өнгөрөгч хорь гучаад онд Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, С.Буяннэмэх нарын зэрэг томоохон сэтгүүлч, зохиолчид тогтмол хэвлэл эрхлэн гаргаж, бүтээл туурвилаа түүнд нийтэлж байсан нь манай социалист утга зохиолын анхны дүр төлөвийг харуулж байлаа... С.Буяннэмэх сонин хэвлэлийн хэл найруулгыг сайжруулах, нийтлэлийн арга барилыг боловсронгуй

болгох, эхлэн бичигчдийг дэмжих талаар нэлээд зүйл хийж, утга зохиолын судлал шүүмжлэлийн холбогдолтой өгүүлэл хэд хэдийг бичжээ”<sup>10</sup> хэмээн тэмдэглэжээ. Энэ тухай судлаач М.Зулькафиль, Б.Уянга зэрэг бусад нөхөд ч нэг биш удаа онцлон өгүүлсэн байдаг.

**1** 1927 онд бичсэн “Ленин” хэмээх алдарт нийтлэлдээ “Одоо дэлхий дээр туйлын хүчтэн нь юу вэ гэвэл эд хөрөнгө бөгөөд хөрөнгөтөн нар болно. Гэтэл түүний оньсыг бут цохисон нь Ленин юм. Тиймээс Ленин гэдэг хүчтэй болой. Ленин дэлхий дахины оньсыг нээхдээ ямар зэвсэг хэрэглэсэн бэ? гэвэл дэлхий дахины үгээгүй үйлдвэрчин ардууд дарлагдсан доромжлогдсон хүн төрөлхтөн болно... Лениний ач гавьяагаар манай Монголын ард эрх чөлөөгөө олж, тусгай эрхтэй улс болсон тул Ленин манай Монголын ачит багш болно. Лениний бодлого нь эв хамт нийгэм журмын суртал бөгөөд түүний явдал бол хувьсгалт явдал болно”<sup>11</sup> хэмээжээ. Ленин хэмээгч хувьсгалын удирдагчийн хүч чадал юунд байна, тэр нь дэлхий нийтийн, түүний дотор Монголын ард түмэнд юу өгөв гэдгийг илүү дутуу үггүй маш товч тодорхойгоор нээн үзүүлжээ.

Доктор, профессор Л.Норовсүрэн “Зөвхөн Лениний тухай бичсэн цуврал нийтлэлээр нь С.Буяннэмэхийн уран бүтээлийн өсөлт, ертөнцийг үзэх үзлийн төлөвшил төдийгүй манай хувьсгалт уран зохиол, нийтлэлийн хөгжлийг харж болох байна”<sup>12</sup> гэжээ. Энэ мэтээр Монголын сэтгүүл зүйн шүүмж судлалын эхлэлийг тавигчдын нэг, чадамгай сэтгүүлч С.Буяннэмэхийн нийтлэлүүдийг судлаачид тал бүрээс нь судлах явдал улам бүр нэмэгдэж байна. Тэдгээрийн тоонд Ц.Дамдинсүрэнгийн “Өндөр хариуцлага, нэр хүндтэй үйлс”,

“Намын амьдрал”. 1970.№10/, Г.Дүйнхэржавын “Улсын алдарт уран зохиолч Буяннэмэх” /”Засгийн газрын мэдээ”. 1992. №41/, “С.Буяннэмэхийн уран бүтээл дэх В.И.Лениний дүр” /”Улаан-Од”. 1969. №90/, Г.Жамсранжавын “Ардын үйлсийн анхны бичээч” /”Үнэн”. 1988. №21/, Ц.Мөнхийн “Сономбалжирын Буяннэмэх” /”Утга зохиол, урлаг”. 1967. №52/, Д.Намдагийн “Шинэ Монголын шинэ театр” /УБ.1988/, Д.Цэн-дийн “Нэгэн мэдээг сурвалжилсан нь” /”Улаанбаатарын мэдээ”. 1974. №2/, Х.Зандраабайдийн “Тал нутгийн хавар” /УБ.2012/, Д.Цэдэв, Ван Мандуга нарын “Сономбалжирын Буяннэмэх” /Түүвэр зохиол. УБ. 2012, 2012-2017/ зэрэг сонирхолтой судалгаануудыг эрхбиш нэрлэн хэлэх нь зүйтэй буй заа.

Оросын судлаач Л.И.Герасимович өөрийн бүтээлдээ С.Буяннэмэхийн тухай тусгайлан өгүүлсэн нь бий бөгөөд БНСУ-ын судлаач Ин Ён “Сономбалжирын Буяннэмэхийн амьдрал, уран бүтээлийн замнал” докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт зохиолдоо “С.Буяннэмэх бол амьд насандаа багтамгүй баялаг намтартай, үйлс бүтээл ихтэй, олон талт арвин их бүтээлтэй хүн” хэмээн онцолсон байдаг билээ.

Д.Цэдэв, Ван Мандуга нар “С.Буяннэмэхийн Цэцэнбилэгт нэрээр гаргаж байсан “Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийн найман дугаар бол тухайн үеийн Хятад орны байдал, хятад Монголын харилцааны асуудлыг тусгасныхаа хувьд үнэт ховор хэрэглэгдэхүүн болно”<sup>13</sup> гэсэн бол судлаач До.Цэнджав “Энэ сэтгүүл есөн дугаар гарч С.Буяннэмэхийг Монгол руугаа буцахтай цуг хаагдаж зогссон байна”<sup>14</sup> гэжээ. С.Буяннэмэх “Дотоод Монголын ардын сэтгүүл”-ийг удирдан гаргасан нь “Дундад улсын цөөн тоот үндэстний үсэг бичгээр эв хамт ёсыг сурталчлан

ухуулсан ууган хувьсгалт сэтгүүл болно” гэж Хятадын хэвлэлийн түүхэнд тэмдэглэгдэж үлдсэнийг ч зохиогч хамтад сануулсан байна. “Юуг уран яруу өгүүлэл хэмээмүй хэмээвээс, ер аливаа нэгэн хэсэг юмны өнгө дүрс буюу утга чанарыг энгийн үгээр илэрхийлэн бичихийн оронд маш гоё сайхан үгсээр түүний байдлыг бичсэн нэгэн хэсэг өгүүллийг “яруу өгүүлэл” хэмээмүй. Өгүүлэл хэмээсэн нь ер нэгэн юмны байдлыг тоочих өгүүллийн чанартай зүйлийг хэлжүхүй.

Уран яруу өгүүлэл болбоос аливаа үлгэр туужийн дотор өргөнөөр хэрэглэгдэх бөгөөд бас зарим нэгэн зүйлийг уран яруу өгүүлээр бичиж сонин сэтгүүлд тавьдаг болой”<sup>15</sup> гэж С.Буяннэмэх “Утга зохиолын онолын үүд” бүтээлдээ тодорхойлон бичжээ.

Энэ бол уран нийтлэлд шууд хамааруулан хэлсэн онолын тодорхойлолтынх нь нэг юм. Өөрөө тэр уран яруу өгүүлэл, холбоо шүлэг, найруулгын том мастер байсан билээ. Тэрбээр уран яруу өгүүллийн, өөрөөр хэлбэл уран нийтлэлийн онолын томъёоллыг ийнхүү гаргаад зогссонгүй сэтгүүлчдэд амин чухал цөөнгүй санаа, жишээ нь бичсэн зүйлээ хэсэг хугацаанд орхиод дараа нь эргэж харж засч сайжруулах хэрэгтэй гэх зэргээр практик зөвлөмжүүдийг бичиж үлдээсэн байдаг юм.

С.Буяннэмэх “Утга зохиолын үүд” онолын зохиолынхоо “Өврийн дэвтэр” гэсэн хэсэгт “Уран зохиолыг бичих санаачилгатай авьяастай хүн болбоос заавал нэгэн энгэрийн дэвтэртэй явах хэрэгтэй. Бичиг зохиолын сэдвийг хүний өгүүлэл ба улс орны хэрэг болон олон нийт хурал цуглаан зах зээл хөдөө гадна, хот балгад ямар ч газар явахдаа сонирхолтой юмны сэдвийг сурвалжлан явах хэрэгтэй. Нэг сонин үг боловч, нэг сонин хэрэг боловч цөм тэмдэглэн авч

явмуй. Тэмдэглэхдээ түүний шалтгаан үүсэл ба хаанаас хэнээс хэрхэн үүдсэн өнгө байдал ба түүний дотор сонирхолтой зүйл нь юу болохыг нарийвчлан шалгаж тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээр нь “материал” нөхцөл болж хэзээ юу зохиоход үлгэр жишээ болгох зүйлүүдийг авах ба мөн түүний дотроос зохистой зүйлийг тусгай зохиол болгож болмуй”<sup>16</sup> гэж бичсэн байна. Түүний дээрх онолын томъёолол болоод практик зөвлөмжийг үе үеийн нийтлэлчид, сэтгүүлчид өөрсдийн үйл ажиллагаанд хэрэглэж мөрдөж бүтээлчээр ашиглах нь дамжиггүй юм. Учир нь С.Буяннэмэх эдгээрт сэтгүүлзүйн амин чухал зайлшгүй зүйлсийг хөндөн өгүүлсэнд оршино.

С.Буяннэмэхийн шүүмж судлалын болон сэтгүүл зүйн бүтээлүүдтэй танилцаж үзсэн зарим судлаач, тухайлбал доктор М.Зулькафиль, докторант Б.Уянга нар “С.Буяннэмэх нь... сэтгүүлзүйн шүүмж судлалын эхлэлийг тавьж, цаашид төлөвшүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн гэж хэлэх бүрэн үндэстэй юм. Ч.Дашням, С.Буяннэмэх нар бол Монголын сэтгүүл зүйн шүүмж судлалыг үндэслэгчид мөн” гэж дүгнэжээ.

Үүнийг миний бие бүрэн дүүрэн хуваалцаж байна. Учир нь С.Буяннэмэх “Утга зохиолын үүд” онолын бүтээлдээ уран яруу нийтлэлийн онолын үндэслэлийг тодорхойлж, зохиолч сэтгүүлч хүн ажигламтгай байж авьяасаа хөгжүүлнэ. Өвөртөө цаг ямагт энгэрийн дэвтэртэй явж үзсэн харсан, ажигласан анзаарсан зүйлээсээ хамгийн чухлыг, сонирхолтойг нь тэмдэглэж авч байвал хожмын бүтээлийн үндсэн материал болно гэдгийг сануулсныг мартаж болохгүй. Эдгээр чухал санаа нь “Монголын сэтгүүл зүйн шүүмж судлалын эхлэлийг тавьж

өргөжүүлэн хөгжүүлэх үндэслэлийг бүрдүүлсэн юм<sup>17</sup>.

Эцэст нь санамсаргүй мэт боловч яах ч аргагүй үнэн бодит нэгэн баримтыг нэмж дурдъя. Д.Нацагдорж 1923 онд “Ардын цэрэг” хэмээх сониныг үүсгэн байгуулж анхны нь эрхлэгчээр ажиллаж уран бүтээлийн их замналаа эхэлсэн бол С.Буяннэмэх 1920 онд Эрхүү хотноо “Монголын үнэн” сонины 6 дугаарыг гардан гаргаснаар өөрийн хувьсгалт тэмцлийн төдийгүй уран бүтээлийн адармаатай атлаа аз жаргал, гуниг зовлонгоор дүүрэн замналаа эхэлсэн байдаг юм.

“Ардын цэрэг” нэрээр эхлээд улмаар “Хувьсгалт улаан цэргийн соёлын зам” “Улаан одон”, “Улаан од” нэрээр залгамжлагдаж, чөлөөлөх дайны үеэр фронтод “Эх орны төлөө” нэртэйгээр хэвлэгдэж, эдүгээгийн “Соёмбо” сониныг хүргэсэн Монголын зэвсэгт хүчний төв хэвлэл 2019 онд түүхт 95 жилийнхээ ойг ёслон тэмдэглэв. “Монголын үнэн” сонин гэсэн нэрээр үйл ажиллагаагаа эхэлж “Уриа”, “Ардын эрх”, “Нийслэлийн сонин”, “Үнэн” нэрээр үргэлжилсээр өнөөдрийн “Монголын үнэн” сонинтой золгосон уг сонины түүхт 100 жилийн ой ирэх 2020 онд тохионо. Эл хоёр сонин бол Монгол Улсын түүхэнд тасралтгүйгээр үргэлжлэн гарсан хоёр хэвлэл мөн билээ. Өөрийн түүхтэй сонин Монголд байхгүй. Үүгээрээ адил төстэй. Нөгөөтэйгүүр “Ардын цэрэг”-ийг ч, “Монголын үнэн” сониныг ч аль алийг манай утга зохиол, сэтгүүл зүйг үүсгэн байгуулж үндэслэгч аугаа хоёр том хүн Д.Нацагдорж ба С.Буяннэмэх нар эрхлэн гаргаж, үүсгэж буй болгожээ гэж бодохоор сэтгэл зүрхэнд цаанаа л нэг ойрхон, туйлын их бэлэг дэмбэрэлтэй санагдаж эрхгүй омгорхон бахархах сэтгэл төрдгөө нуух юун билээ.

С.Буяннэмэхийн сэтгүүлчийн үйл ажиллагааг хөндөх юм бол онцгойлон тодотгож ярих учиртай нэг зүйл бий. Энэ бол түүний бичсэн “Гайхамшигт учрал” найруулал. Зохиогч анх 1922 оны 1-р сард Москвад Алс дорнодын хувьсгалт байгууллагын анхдугаар их хуралд Монголын залуучуудыг төлөөлж оролцох үеэрээ Ленинийг харжээ. Тэр “Ленин” нийтлэлээ 1927 онд, “Гайхамшигт учрал” найрууллаа 1935 онд тус тус хэвлүүлсэн байна. Бичлэгийн арга хэлбэр, зохиомж нь онц сонирхолтой. Уг уулзалтад С.Буяннэмэх хожигдосхийн орсон тул суух сандал олдсонгүй. Халзан толгойтой нэгэн орос хүн түүнд өөрийн сууж байсан сандлаа найр тавин өгчээ. Найруулал ингэж эхэлж байна. Үйл явдлын эхлэлийг маш чадмагаар зохиомжилжээ. Гэтэл тэр хүн орон бүрийн залуучуудын төлөөлөгчидтэй янз бүрийн хэлээр ярьж асуултанд нь хариулж байв. Хүн төрөлхтний хувь заяа, нийгмийн байгууллын шинж төрх, цаг үеийн асуудлаар гүнзгий мэргэшсэн их эрдэмт хүн болох нь төдөлгүй түүнд анзаарагдана. Энэ юун хүн болохыг орчуулагч Ишдоржоос олж мэдсэн С.Буяннэмэх санаа ихэд зовинож, сэтгэл уйман сандлаас бушуухан босч түүнтэй хуваалцан суугаад олон улсын ажилчин анги, коммунист ажилчны хөдөлгөөн, хувьсгалт үйл хэргийнх нь сургаалыг сэтгэл догдлон сонсож байна. Эл мартагдашгүй уулзалтынхаа талаар С.Буяннэмэх хожим “Гайхамшигт учрал” найруулал бичиж, түүндээ “Бид Лениний зургийг нэлээд хэд үзсэн боловч их төлөв зураг дээрээ хар үстэй, их биетэй бас төдий л их өвгөрсөн байдалгүй мэт харагддаг билээ. Гэтэл чухам бодитой бие байдлыг үзвээс хар үстэй биш шав шар үстэй, багавтар биетэй, бяцхан нүдтэй, их халзан толгойтой, бүдүүн гар



хуруутай харагдсан бөгөөд харин нөхөр Ишдоржийг үзэхэд болбол яв ягаан том халзан толгойтой нь Монголын хуучны Эрдэнэ цагаан өвгөн хэмээгч лүгээ бараг төлөв адил магнай духтай байсан хэмээдэг болой” гэж дүрсэлж бичжээ. Ер бусын Ленин багш түүнд ер бусын үзэгдэж. Орчуулагч Ишдоржид ч мөн ялгаагүй. Арай илүү философилог харагдаж. Энэ бол зөвхөн гадаад өнгө төрх. Түүний дотоод ертөнцийг зохиогч дэлхийн хувьсгалын зорилго, хэрэгжүүлэх арга зам, практикийг тэдэнд ярьж байгаа, улс орон бүрийн залуусын сонирхсон асуултад тэр ястан үндэстнийх нь хэл дээр хариулж тайлбарлаж байгаагаар илэрхийлэн гаргасан байна.

С.Буяннэмэх бол зөвхөн зохиолч, сэтгүүлч, яруу найрагч, утга зохиол судлаач байсангүй. Бас муугүй зураач хүн байжээ. Урлаг утга зохиол судлаач С.Лувсанвандан марзан Шаравын зурсан Ленин багш хөргийн зохиомжийг С.Буяннэмэхийн эрхэлж гаргасан “Уран үгсийн чуулган”-ны хавтасны зурагтай харьцуулж үзээд ерөнхий зохиомж, дүрслэл төсөөтэйг анзаарч, түүний хэлж зөвлөснөөр бүтээсэн байж болзошгүй гэж тэмдэглэсэн нь үндэстэй мэт санагдана.

Зохиогч найруулалдаа Лениний гадаад дүр төрхийг эхэлж зурж үзүүлээд улмаар түүний дотоод ертөнц, эрдэм ухааны аугаа их ундаргыг нээн гаргажээ. Энэ бол Лениний дүрийг Монголын уншигчдад хүргэсэн анхны найруулал байсан юм. Ленин гэж хэн бэ гэдэгт “Гайхамшигт учрал” найруулал хариулт өгч чаджээ. Зохиогч найруулалдаа их Лениний дүрийг бүтээж, түүний үзэл санааг үгээр илэрхийлэн зурж гаргасан гэж хэлж болно. Энэ бол Монголын утга зохиол, нийтлэл зүйд монгол зохиолч, сэтгүүлчийн бүтээсэн хамгийн анхны Лениний бодит дүр

байсан юм. Уран зургаар зүйрлэн үлгэрлэбэл марзан Шаравын Ленин багшийн хөрөгтэй адилхан гэж хэлж болно. С.Буяннэмэх бол өөрөө муугүй зураач хүн байсан бөгөөд “Монголын үнэн” сонины 6 дугаар дахь зураасан зургуудыг тэр өөрөө зурсан гэдэг үндэслэлтэй мэдээлэл бий.

**Д**октор С.Лувсанвандан өөрийн судалгааны зохиолдоо С.Буяннэмэх 1929 онд “Уран үгсийн чуулган”-ыг гаргахдаа хавтсан дээрх усан будгийн чимэг зургийг өөрөө зохиомжилсон байж таарна. Тэрхүү дэлхийн бөмбөрцгийн дүрстэй “Үнэн” сонины 1929 оны 3-р сарын 10-ны дугаарт Б.Шаравын нийтлүүлсэн дэлхийн бөмбөрцгийн дэлгэцэн дээр Лениний хөргийг зохиомжилсон байдал адил байгаа нь анхаарал татаж байна. Уг зургийн санаа зохиомжийг С.Буяннэмэх зураачид хэлж өгсөн юм биш биз гэсэн таамаглал дэвшүүлээд “1923 онд Б.Шарав Лениний хөргийг бүтээх тэр үед, зураачаас сэдэв, уран санаа, зохиомжоо шийдэхэд ямар хүчин зүйл нөлөөлөв гэсэн асуудал аяндаа гарч ирнэ. Тэр үед 1920 оноос оросын большевикүүдтэй хамт Коминтерний байгууллагад ажиллаж, ЗХУ-д удаа дараа очиж байсан хүн бол С.Буяннэмэх байлаа. 1921 онд дэлхийн коммунист интернационалийн V хуралд оролцож ирээд “Залуучуудын зорилт” дуугаа бичсэн юм. 1922 оны өвөл В.И.Ленинтэй нүүр учран золгож ирээд “Монгол интернационал” дуугаа зохиожээ. С.Буяннэмэх “Ленин” нийтлэлээ 1927 онд, “Гайхамшигт учрал” найрууллаа 1935 онд хэвлүүлжээ. Гагцхүү эдгээр зохиолд нэвтэрсэн нэг санаа, нийтлэг дүр бол үлэмжийн их Лениний үзэл санаа, түүний дүр зураг билээ. Тиймээс тухайн зохиолуудын дүр дүрслэлийг

Б.Шаравын хөргийн зохиомж, хэллэгтэй харьцуулан үзэх үндэстэй юм”<sup>18</sup> гэжээ.

Эл таамаглалыг би хувьдаа үнэн бодит байдалтай ихэд дөхөж очсон, нэг их хол зөрөхгүй тайлал мөн болов уу гэж бодож байна. 1923 оны 7-р сарын 19-нд С.Буяннэмэх МАХН-ын II их хуралд Намын Төв Хорооны улс төрийн илтгэлийг тавьж хэлэлцүүлж байсан бөгөөд тус их хурлаас сонгогдсон 7 тэргүүлэгч гишүүнд 1923 оны 8-р сарын 13-ны өдрийн 14-р хурлаар ажил үүрэг хуваарилахад С.Буяннэмэхэд Зохиолын хэлтсийн эрхлэгчийн үүрэгт ажлыг хариуцуулж тохоон томилсон байдаг билээ. Энэ бол намын үзэл суртлын гол ачааг түүнд үүрүүлсэн гэсэн үг. С.Буяннэмэх ардын хувьсгалыг мандуулахаас эхлээд хувьсгалын үйлсэд чин үнэнчээр хүчин зүтгэж, 1921 оны 8-р сарын 25-нд Бошгыг халах залуучуудын эвлэлийг байгуулахад гишүүнээр элсэж, улмаар тэргүүлэгчээр сонгогдон, 1922 онд хуралдсан МХЗЭ-ийн анхдугаар их хурлаас Эвлэлийн Төв Хорооны даргаар сонгогдоод залуучуудын ажлыг идэвхжүүлэн зохион байгуулахдаа урлаг, утга зохиол, шүлэг, ший жүжиг зэргийг дээд зэргээр чадамгайгаар ашиглаж эхэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл тэр тухайн цаг үедээ нам, эвлэлийн мэргэшсэн улс төрийн ажилтан, тэргүүлэх үзэл сурталч нь байжээ.

**Х**үн төрөлхтний түүхэнд улс орнууд сонин сэтгүүл гаргаж эхэлснээр мэргэжлийн сэтгүүл зүй сонгодог утгаараа үүссэн гэж үздэг. Монголд энэ ажил 1913 онд буй болжээ. Их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээн 1913 оны 3-р сарын 6-нд “Шинэ толь хэмээх бичиг” сонины анхны дугаарыг хэвлэн гаргаснаар Монголын үндэсний сэтгүүл зүй төрж мэндэлсэн түүхтэй. Тус сонины 1913 оны №5-д “Сонсгол”

гэсэн гарчгийн дор сонирхолтой мэдээлэл нийтлэгдсэн байна. Уг мэдээнд:

“Сонсвоос ерөнхий сайд сайн ноён хан Хантан Орос улсад явж олон улсын хэрэг зөвлөх хуралдааны дүрэм хэмжээг авч ирээд Монгол Улсын хэргийг зөвлөх ба бага хоёр хуралдаан байгуулахыг айлдаад хариу хүлээж буй хэмээмүй. Энэ нь монгол сайд түшмэд, ихээхэн эрхтнүүд улс төрийн хуралдаанаар хамтран хэлэлцэж хүн бүр саналаа илтгэн гаргаж, хэрэг учрыг нарийвчлан зөвлөх болсон нь Монгол Улсын эрх баригчид жил ирэх тутам улмаар мэрэгжин, улсыг засах арга олсон нь мөн ажгуу.

Улсын хуралдааныг даруй байгуулж, газар бүрийн жаргал зовлон, засах бадруулах, сахин хамгаалах олон чухлыг нарийвчлан хэлэлцэж тустай сайныг үзэж шийтгэн тогтоох ба ард нийгмийн саналыг нэгэнд нийтлүүлэн гол засгийн газраа хүчин нэмэгдүүлж, улсыг төвшитгөн засахад бат багана мэт түшиг болно. Олон улсууд бүгд хуралдаан байгуулж, сонголтын хүмүүн нар төлөөнөө илэрхийлэн улсын хэргийг зөвлөдөг байна” гэжээ.

“Шинэ толь хэмээх бичиг” сонин энэ сэдвийг ахин дахин хөндөж тавьсан аж. Сонины 11 дэх дугаарт “Улс төрийг тулгуур тогтнуулан засна гэгэч чухамхүү амаргүй хэрэг ажгуу. Ялангуяа улс нь хүчин чадал олоогүй үндэс нь батжаагүй аливаа боловсрол хөгжөөгүй нялх хүүхэд болбоос засгийг тогтнуулж бүрэн бүтэн болгоход нэн ч бэрх болой. Ганцхан улсын эзнийг ширээнд залж засгийн хэрэг шийтгэх газар байгуулан хууль, дүрэм төдийгөөр улс төр хүчирхэг бат болох нь бус. Улсыг хүчирхэг ба баялаг эрдэмтэй боловсон болгож ард түмнийг энхжүүлэн жаргуулж гадна дотныг аюулгүй болгон гүйцэтгэсүгэй хэмээвээс улсыг засах

захирах хоёр нь гүн мэргэн бөгөөд хичээлтэй хурц болбоос сая улсыг мандуулж чадна. Хэрэв улсын эзэн ба улсын хэргийг шийтгэх засгийн газар нь улсыг сайнаар засч захирахгүй бол улсыг мандуулах байтугай харин хоосруулах элдэв буюу мөхүүлж болно. Хуучин түүх үзвээс улсын хэргийг муугаар шийтгэсний улмаас хүчирхэг байсныг бууруулан эвдсэн газар олон үзэгдэнэ.

Дэлхий дээрх олон улсын түүхэнд үзвэл улсын эрх баригчид эрдэмтэй мэргэн сүсэгтэй номч боловч ард албат зүдгүүр зовлон амсаж, хөрөнгө хогшил барагдан гадна дотны элдэв зүйлийн харш хөнөөлөө улам бүр доройтон буурах болсон нь үзэгдэнэ. /Үүнд зохиогч Тогоонтөмөр, IV Иван, XIV Людовик нарын амгалан жаргаланг эрхэмлэх нь ихэдсэнийг дурьдаад тэдний хэрцгий догшин, садар самуун, бардам дээрэлхүү дутагдлыг цохон тэмдэглэжээ.

... Бас эзний хүнд хишиг хүртсэн дээ эрдэн, шадар бараа бологсод элдвээр зусардан энэ тэрнийг ховлон муутгах ба мууг магтах тэргүүтэн зүйл бүрээр гүтгэж, эзнийг гэнэхнээр улс төр, ард түмэнд тусгүй харштай хууль цааз гаргах ба зарлиг буулгаж, эзний зарлиг хэмээн далайлгаж айлгаж, өөрийн амины хэргийг бүтээх нь олон үзэгдэнэ. Ард албатыг элдэв эрдэмд боловсруулан сайнаар удирдахыг хол таягдаж улсын сан хөрөнгийг гамнах аривлахыг огоорон, гэдэс хэтэвчийг дүүргэхийг эрхэм болгох нь үзэгдмүй. Энэ мэтийн улмаас ард албат гомдож, зан сэтгэл догшрон улам самуурч, хоорондоо алалцан, муу засгийг халах гэм хийцгээнэ хэмээн номложээ” гэсэн байна.

Өгүүлэлд хамтын оюун ухаан, хамтын хүчин чармайлт улс орныг удирдахад ямар их хэрэгтэйг тайлбар-

лаж ганцхан улсын эзнийг ширээнд залж засгийн хэрэг шийтгэх газар байгуулан, хууль дүрэм төдийгөөр улс төр хүчирхэг байж болохгүй. Хэрэв улсын эзэн ба улсын хэргийг шийтгэх Засгийн газар нь улсыг сайнаар засч захирахгүй бол улсыг мандуулах байтугай харин хоосруулж мөхүүлж болно хэмээн анхааруулаад хамтын хуралдааныг талархан сайшаажээ. Өгүүллээс харахад ганцаар захирах хаант засаглалд илэрхий шүүмжлэнгүй хандсан байна.

**У**г сэдвийг “Шинэ толь хэмээх бичиг” сонин 1914 оны 5-р сарын 17-ны № 12-т ахин хөндөж эл сэдвийг үргэлжлүүлэн нийтэлжээ. Хоорондоо долоо хоногийн зайтайгаар хэвлэгдэн гарсан энэ хоёр дугаар олон хүний анхаарал татсан нь лавтай. Талархсан хийгээд дургуйцсан аль аль нь байсан болов уу. Учир нь уг сэдэв маш хурц, олон олон хүний эрх ашгийг хөндсөн, Монгол Улсын ирээдүйтэй холбоотой асуудал байсанд оршино.

Хоёр дахь дугаарын үргэлжлэлд нийтлэгдсэн өгүүллээс үзэхэд сониныхон хамтын хуралдааны энэхүү дэвшилт хэлбэр нь гэнэт гарч ирээгүй бөгөөд олон улс оронд байдаг дэвшилт зүйл мөн гэдгийг өмнөх дугаартаа хангалттай тайлбарласан ч үргэлжлүүлээд №12-т парламент ёс нь Монголд цоо шинэ зүйл бишээ. Энэ бол их эзэн Богд Чингис хааны үеэс уламжлагдан ирсэн удирдлагын дэвшилт хэлбэр юм гэж уншигчдад үнэмшүүлэн итгүүлэхийг илэрхий оролджээ.

Богд хаант Монгол Улсын Ерөнхий сайд “Шинэ толь хэмээх бичиг” сонин дээрх мэдээллийг уншиж байгаагаар С.Буяннэмэхийн “Сандо амбан” буюу “Ойрхи цагийн товч түүх” жүжгийн “Улсын дээд доорд хоёр хурал мэтийг байгуулсан нь” хэмээх дөрөв-

дүгээр бүлэг нээгдэж байна. Хөшиг нээхэд Сайн ноён хан гэртээ суугаад бичиг уншиж байх бөгөөд нэгэн хиа сонин сэтгүүл авчран түүнд өгнө. Тэр уг сонин бичгийг уншиж үзээд өөрөө өөртөө “Энэ сонин бичгийг ямар эрдэмтэн гаргаж буй болгов? Би үзвээс үүнийг гаргаж буй хүн нь үнэхээр монгол үндсийг бодож зүйл зүйлээр санаа сүвэгчлэн, бидний зэрэг сайд хэмээгдсэнийг ятган сануулж улсын засгийг улам шударга ариунаар явуулахыг хичээсэн нэн ч туйлын бодлого болжихуй”<sup>19</sup> гэж хэлж байна. Тэгээд “Энэ маш зөв хэрэг мэт санагдана. Үүний дотор бичсэн нь бидний өвөг Чингис хаан улсын засгийг явуулахдаа олон тушаалтан их бага нийтийг хуралдуулж олны саналыг авч хэргийг шийтгэж байсан учир тийнхүү мэргэнээр төрийг засаж, бодлого хурц мэргэн баатар арга одоо хүртэл алдаржихуй хэмээсэн ба бас эдүгээгийн дэлхий дэх олон улсын дотор улсын хурал хэмээн олон ардыг хуралдуулж засгийн хэргийг явуулдаг хэмээн биччихүй. Үүнд санаваас энэ хэрэг маш үнэн сайн хэрэг мэт тул зүй нь бидний монголчууд мөн ч ийм хурал байгуулбаас сайн ажээ... Энэ хэргийг одоо даруй эс гүйцэтгэвээс цаг оройтох юу магад”<sup>20</sup> хэмээн нэгэн хиаг дуудаж Эрдэнэ шанзүдва ба Далай дайчин ван нарыг залж авчрахтун, хэлэлцэх чухал хэрэг байна гээд явуулж байна.

**Т**эднийг гэртээ цуглуулаад “Сайн хан хэлмүй-Эдүгээ байцааваас дэлхий дээрх олон улс засгийн хэргийг илтгэхдээ улсын хурал байгуулж олны саналыг авч хэрэг шийтгэж бүхий учир зүйд тавтайяа нийлэлцэх тул манай монголчууд ч мөн ёсоор улсын дээд доорд хоёр хурал байгуулбаас сайн мэт санагдмуй” гэж хэлээд тэдний асуултад хариулж дээд доод

хурлын зорилго үйл ажиллагааг тайлбарлаж байна.

Шанзодва хариуд нь “Би санаваас энэ хурлыг байгуулах боловч зөвхөн сайд түшмэд нарыг хуралдуулбаас зохимуй. Хэрэв энэ тэр ард, аймгийн төлөөлөгч хэмээн хуралдуулах аваас тэд нар олонхийн санал хэмээн аливаа хэргийг шүүрэн эрх мэдэлд харш болох ч юу нь магад. Эрхбиш болгоомжилбоос зохимуй” хэмээн анхааруулж бусад нь дэмжиж байгаа талаар өгүүлжээ. Сайн хантан тэдэнд “Би үзвээс манай Монголын дээд өвөг Чингис хаан улсын хурал байгуулан, засгийн хэргийг олонхийн саналаар шийтгэж байсан учраа, аливаа хэрэг хүчин төгөлдөр болж тийнхүү дэлхий дахинд алдаршиж чадсан аж. Одоо би өвгийн суртлыг дагахад дэмий л татгалзах учир юун буй”<sup>21</sup> гэх зэргээр ятгаж дээд доод хурлыг байгуулахаар болж буйг жүжигт үзүүлжээ. Улсын дээд хуралд олон яамны тэргүүн дэд сайд, Эрдэнэ шанзодва хутагт, Да лам нарын зэрэг хүмүүсийг оруулж, харин улсын доод хуралд олон яамны түшмэдийн зэрэг тушаалтан нарыг оруулж хуралдуулж байх саналыг Сайн хантан гаргаж, бусад нь зөвшөөрч байна.

Богд хаант Монгол Улсын засаг төрд улсын дээд ба доод хурал ингэж байгуулагджээ. Энэ тухай “Шинэ толь хэмээх бичиг” сонин мөн уншигчиддаа мэдээлж, цаашдын үйл ажиллагаанд нь ихэд шүүмжлэлтэй хандсан байдаг билээ. Тэр тухай мэдээг дор толилуулья. Тус сонины 1914 оны 8-р сарын 21-ний өдрийн №20-д “Бяцхан өгүүлэл” нэртэй хурц шүүмжлэл нийтэлжээ. Тэр дотор “... Монголын дээд доод хоёр хурлын дотоод тогтоосон дүрэм хэмжээ огт үгүй тул аливаа хэргийг зөвлөн хэлэлцэх журамгүй хэмээнэ. Дээд хуралд тавь жаран сайд ноёд хуучлах

боловч хэдхэн тэргүүн сайд дарангуйлан шийтгэх тул хурлын зөвлөснийг хоосонд аваачих нь олон хэмээнэ. Доод хуралд дал наян хүн цуглах боловч хурлын даргагүй тул нэг хэдэн дэд түшмэд дарангуйлан шийтгэнэ гэнэ. Хурлын чухал дүрэм батлуулсан нь хэдэн жин шар тос торгохоос өөрцгүй гэнэ”<sup>22</sup> гэжээ.

**Ү**үнийг үнэн болохыг С.Буяннэмэх баталгаажуулж өөрийн жүжигтээ нэгээхэн бүлгээр нээж үзүүлжээ. Тэр тухайг үргэлжлүүлэн сонирхуулсугай. Уг тавдугаар бүлгийн гарчиг нь “Автономит засгийн дээд доод хурлын байдал нь” хэмээх бөлгөө. Хөшиг нээгдэхэд нэгэн хиа орж ирж Дархан хошой чин вантан хижиг өвчин хүртэж чөлөө айлтгасугай гэж хэлнэ. Бас нэгэн зарлага орж ирж Эрдэнэ далай вантан хөл хавсаж цавь цоорсон учраа энэ өдрийн хурлаас чөлөө мэдүүлмүй гэнэ. Өөр нэгэн мөн л адил Да ламтан бөөрийн өвчин хүртсэн тул хурлаас чөлөө өгөхийг гуйж байна гэж хэлж байна. Энэ мэтээр хурлаас чөлөө хүсэгчид нэг биш байх ажээ.

Эрх мэдэлтнүүд энэ мэтийг хэлэлцээд бөөр хавдав, цавь цооров, булчирхай цочив, хөл өвдөв, хижиг хүртэв гэх зэргээр тэмдэглэх нь зохимжгүй сонсогдож байна. Иймд ханиад хүртэв гэх мэтээр бичиж тэмдэглэж хурлаас чөлөөлж байх хэмээн ярьж тохиролцоно. Яаруу ажил хэрэг гарсан Ерөнхий сайд хурлаас гарч явахад үлдэгсэд нь өнөөдөр юуг хэлэлцвэл зүйтэй вэ хэмээн ам амандаа шуугилдана.

Нэгэн гүн хэлрүүн: Надур нэгэн айлтгаар хэрэг буй... Өчрүүн: Миний бие гурав хоногийн урьд Сэцэн вангийн хошууны нэгэн айлд орсон билээ. Гэтэл нэгэн сайхан гоо үзэсгэлэнт хүүхэн сууж буй. Би үзсэн цагаас нааш одоо зүрх

түгшсээр буй. Би сонсвоос тэр хүүхэн нь нэгэн их тушаалын эрдэмтэн сайдад холбоовоос сайн хэмээн санадаг билээ хэмээхэд

Вантан хэлрүүн: Ай яасан зол билээ. Би эдүгээ хүртэл хэдэн авгайтай бөлгөө. Одоо харин тэр хүүхнийг авбаас яасан сайн болов хэмээн шүлсээ гоожуулмуй.

Гүнтэн хэлмүй: Гагцхүү өгөхгүйгээс эмээхүй хэмээхэд

Вантан хэлмүй: Тэр юунд үл өгмүй. Би хэмээгч улстөрийн багана бөгөөд тушаал хэмээвээс вангийн зэрэгт хүрч үе улиран мянган лангийн пүнлүү хүртэж бас хошуу хотлыг дураар эдэлсэн ийм их ноёнд юунд үл өгмүй хэмээхэд гүнтэн хэлмүй: Энэ маш зөв болов хэмээтэл

Вантан хэлрүүн:- Тэр маш сонин хэрэг ажгуу. Тийм бөгөөс ямар хүнд өгдөг болов хэмээхэд гүнтэн хэлрүүн:- Түүний өгөхгүйгээс юунд зовмуй. Вантан та Богд эзэн хаанд зоос даншиг өргөж завшаан айлтгаад зарлиг зөвшөөрвөөс тэр муусайчуул өгөхгүй хэмээн чадах буюу хэмээхэд бүгдээр:- Энэ маш зөв арга болов. Ван яа таны заяа буян иржихүй хэмээлцэв.

Чин ван лам хэлрүүн:-Би өчигдөр зах дээр явж байтал нэгэн ногоон торгон дээлтэй хүн нэгэн сайн жороо морь унаж явмуй. Би тэр жороо мориог үзээд үнэхээр бахдаж хорхой хүрэв. Эрхмүүд тэр жороо морины эзнийг танимуй хэмээхэд гүнтэн хэлрүүн: -Тэр морины эзнийг би танимуй. Ламтан дурлах аваас би асууж өгч болмуй. Тэр ч байтугай зүгээр өргөчихөж болмуй хэмээхэд Чин ван лам ихэд баярлан хэлрүүн: -Тийм бөгөөс танай ачийг бүү умартсугай хэмээв. Тийнхүү удалгүй бүгдээр: -Чөлөөлсүгэй. Энэ өдрийн хурал маш сайн хурал болов хэмээлцэн

хиа нараа зандралцан мордож явцгаамагц хөшиг хаамуй”<sup>23</sup> гэжээ.

Сэтгүүлч, судлаач С.Буяннэмэх зөвхөн өөрөө бичиж туурвиж, сонин сэтгүүл гаргаад зогссонгүй Монголын сэтгүүл зүйн үр нөлөөт үйл ажиллагааг зохиол бүтээлээрээ сурталчлан таниулагч нэгэн байсныг бид “Ойрхи цагийн товч түүх” жүжгийн дээрх 4, 5 дугаар бүлгээс нэн тод харж байна. Тэрбээр “Шинэ толь хэмээх бичиг” сонины нийтлэл тухайн цаг үедээ Монголын нийгэмд яаж нөлөөлж байсныг, бас дутагдал доголдлыг хурц дайчингуйгаар хэрхэн шүүмжилж чаддаг байсныг өөрийн жүжигтээ ийнхүү нэн үзүүлжээ. Монголын анхны сонины үйл ажиллагааг Монголын шинэ үеийн анхны жүжигт дүрслэн үзүүлсэн үгийн мастер нь С.Буяннэмэх болж мөнхрөн үлджээ. Энэ бол сонирхолтой баримт юм.

Энэ бүгдээс С.Буяннэмэх гэдэг хүн бол зөвхөн яруу найрагч, үргэлжилсэн үгийн болоод жүжгийн зохиолч, утга зохиолын ба сэтгүүл зүйн шүүмжлэгч, судлаач төдийгүй шинэ Монгол Улсын анхны гарамгай нийтлэлч, гайхамшигт сэтгүүлч байсныг тодорхой харж болохоор байна. Түүний сэтгүүлчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн

гүнзгийрүүлж судлах нь Монголын сэтгүүл зүйн судлалын нэг тулгамдсан асуудал яах аргагүй мөн болно.

- С.Буяннэмэхийн сэтгүүлчийн үйл ажиллагааг тал бүрээс нь шүүн тунгааж үзвэл дорхи үндсэн үнэлгээ дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд: - “Монголын үнэн” сониныг тухайн цаг үед санаачлан шийдвэр гаргагч нь мэдээж МАН байсан нь үнэн боловч хилийн чанадад 6 дугаарыг гардан эрхэлж гаргасан нь С.Буяннэмэх мөн юм. Иймд түүнийг шинэ Монголын түүхэн дэх анхны ангич, намч хэвлэлийг үүсгэн байгуулагч гэж үзэх бүрэн үндэстэй байна. С.Буяннэмэх бол 1920 оны “Монголын үнэн” сониныг үүсгэн үндэслэгч эрхлэгч мөн.

- С.Буяннэмэх манай сэтгүүл зүйн салбараас мөн анх удаа Өвөр Монгол ба Буриадад уригдаж ажилласан сэтгүүл зүйн мэргэжилтэн байжээ. Өвөр Монголд “Дотоод Монголын ардын сэтгүүл”, Буриадад “Уран үгсийн чимэг” сэтгүүл гаргалцахад идэвхилэн оролцож байсан үйл ажиллагаагаар энэ нь батлагдаж байна.

-С.Буяннэмэх Монголын утга зохиолын онолын судлалыг төдийгүй манай сэтгүүл зүйн салбарын шүүмж судлалыг үндэслэгч гэдэг нь түүний



**Сэтгүүлч, судлаач С.Буяннэмэх зөвхөн өөрөө бичиж туурвиж, сонин сэтгүүл гаргаад зогссонгүй Монголын сэтгүүл зүйн үр нөлөөт үйл ажиллагааг зохиол бүтээлээрээ сурталчлан таниулагч нэгэн байсныг бид “Ойрхи цагийн товч түүх” жүжгийн дээрх 4, 5 дугаар бүлгээс нэн тод харж байна. Тэрбээр “Шинэ толь хэмээх бичиг” сонины нийтлэл тухайн цаг үедээ Монголын нийгэмд яаж нөлөөлж байсныг, бас дутагдал доголдлыг хурц дайчингуйгаар хэрхэн шүүмжилж чаддаг байсныг өөрийн жүжигтээ ийнхүү нэн үзүүлжээ. Монголын анхны сонины үйл ажиллагааг Монголын шинэ үеийн анхны жүжигт дүрслэн үзүүлсэн үгийн мастер нь С.Буяннэмэх болж түүхэнд мөнхрөн үлджээ**



“Утга зохиолын үүд” бүтээл, бусад олон шүүмж судлалын өгүүллээр нь нотлогдоно.

-С.Буяннэмэх шинэ Монголын сэтгүүл зүйн бичлэг дэх төрөл, зүйлийг хөгжүүлэхэд өөрийн бүтээл туурвилаараа хүчтэй нөлөө үзүүлжээ. Түүний туурвисан “Ленин”, “Гайхамшигт учрал” найрууллыг шинэ Монголын сэтгүүл зүйн түүхэн дэх үлгэр жишээг үзүүлсэн анхны сонгомол хөрөг найруулал гэж үзвэл зохино.

С.Буяннэмэх манай сэтгүүл зүйг үндэслэгч Жамсраны Цэвээн гуайтай бүр эртээс ойр дотнын харилцаатай байж, 1913 онд түүний гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонины, тэнд ажиллагч анхны сэтгүүлчдийн үйл ажиллагаа, үнэн бодит баримт сэлтийг “Ойрхи цагийн товч түүх” жүжигтээ бичиж үлдээснээрээ ч мөн гавьяатай нэгэн гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

#### Ишлэл

- <sup>1</sup>Зандраабайдий Х. 2012. Тал нутгийн хүүрнэл УБ., х.20.
- <sup>2</sup>Мөн тэнд. х. 2.
- <sup>3</sup>Мөн тэнд. х. 22.
- <sup>4</sup>Мөн тэнд. х. 23.
- <sup>5</sup>Х.Зандраабайдий. Тал нутгийн хүүрнэл. УБ. 2002. х.22.
- <sup>6</sup>Мөн тэнд.
- <sup>7</sup>Сономбалжирын Буяннэмэх УБ. 2017. Боть IV. х.48-49 .
- <sup>8</sup>Мөн тэнд. х. 45-46.
- <sup>9</sup>Зулькафиль М., Уянга Б. Монголын сэтгүүлзүйн шүүмж судлал: түүний өчигдөр ба өнөөдөр. УБ. 2013. х.22.
- <sup>10</sup>Дэлэг Г. Монголын хэвлэл. УБ. 2014. х.286, 290 .
- <sup>11</sup>“Уран үгсийн чимэг” Дээд Үд. 1927. х.38-39.
- <sup>12</sup>Норовсүрэн Л.. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Боть I. УБ. 2001. х.112.
- <sup>13</sup>Сономбалжирын Буяннэмэх. УБ., 2012. Боть I. Өмнөтгөл. х.19.

- <sup>14</sup>Цэнджав До. Утга зохиолын судлал шүүмжлэлийн өгүүллүүд. УБ. , 2017. х.88.
- <sup>15</sup>Сономбалжирын Буяннэмэх. УБ. 2017. Боть IV. х.328 .
- <sup>16</sup>Мөн тэнд. х. 339 .
- <sup>17</sup>М.Зулькафиль, Б.Уянга. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Түүний өчигдөр ба өнөөдөр. УБ., 2013. х. 30.
- <sup>18</sup>Лувсанвандан С. Монголын уран зохиолын дэвшил, социалист реализм. УБ., 1987. х.250-251.
- <sup>19</sup>Сономбалжирын Буяннэмэх. Дэд боть. УБ. 2012-2015. х.316 .
- <sup>20</sup>Мөн тэнд. х. 316-317 .
- <sup>21</sup>Мөн тэнд. х. 318 .
- <sup>22</sup>Баасансүрэн Т. Монголд чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ. 2009. х.88-89 .
- <sup>23</sup>Сономбалжирийн Буяннэмэх. УБ. 2012-2015. Дэд боть. х.321.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. Монголд чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ. 2009
2. Дэлэг Г. Монголын хэвлэл. Боть I (Хоёр дахь хэвлэл). УБ. 2014
3. Зандраабайдий Х. Тал нутгийн хүүрнэл. УБ. 2012.
4. Зулькафиль М., Б.Уянга. Монголын сэтгүүлзүйн шүүмж судлал: түүний өчигдөр ба өнөөдөр. УБ. 2013.
5. Лувсанвандан С. Монголын утга зохиолын дэвшил, социалист реализм. УБ. 1987
6. Норовсүрэн Л. Монголын сэтгүүлзүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ., 2001.
7. Сономбалжирын Буяннэмэх УБ, 2017. Боть I, II, IV. УБ., 1912-1915.
8. Цэнджав До. Утга зохиолын судлал шүүмжлэлийн өгүүллүүд. УБ. 2017.

#### Резюме

Данная статья является новым словом в оценке деятельности на журналистском поприще одного из основоположников современной монгольской литературы и журналистики С.Буяннэмэха. Новизна статьи также состоит в том, что автор на основе новых фактов и архивных документов, раскрывает ведущую роль С.Буяннэмэха в возникновении и развитии теории журналистики в Монголии.